

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн, санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/89/СТА-ТӨХК

АГУУЛГА

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1 Оршил	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	7
2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	8
2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10 Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11 Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	16
4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ
ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ Р.НЯМТУУЛ ТАНАА

2019.03.14 № 06/431
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1–д заасны дагуу, тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг тус компанийн захирал Р.Нямтуул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн захиралд хүргүүлэхээр төлөвлөн, “Далайван Аудит” ХХК-ийн ахлах аудитор Ц.Ганболд, аудиторын туслах Э.Төгөлдөр, Н.Энхцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг Далайван Аудит ХХК-нд 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 81 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Байгальд ээлтэй экологийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг эрчим хүчээр тасралтгүй хангах зорилттой.

Үйл ажиллагааны чиглэл:

Дотоодын эрчим хүчний эх үүсвэрээр баруун бүс нутгийг хангах, цахилгаан дамжуулах төвийн бүсийн системтэй зэрэгцэн ажиллах нэгдсэн системд шилжихэд оршино.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн удирдлага дараах хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татвар, нийгмийн даатгалын багц хуулиуд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд эрчим хүчний алдагдлийг хэрхэн бүртгэж тайлагнах талаар нарийвчилсан бодлого, арга аргачлалыг тус бодлогын баримт бичигт тусгаагүй байна.

"Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд аудитын багт мэдээллийн технологийн мэргэжилтэн ажиллах шаардлагагүй гэж үзэв.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Апекс” програм хангамж ашигладаг байна.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэллээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн бэлтгэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын 2 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь "Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн нь өөрийн үйл ажиллагаанаас санхүүжигддэг тул орлогын дүнгээс тооцох нь илүү бодитой гэж үзсэн.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны нийт орлого нь 22,425.0 сая төгрөгийн 2 хувь болох 448.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр, аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

Урьдчилж төлсөн зардал:

Урьдчилж төлсөн зардал дансанд 54.4 сая төгрөгийг сөрөг утгаар илэрхийлж алдаатай бүртгэл хөтөлсөн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5.1.4-д “*үнэн зөв байх*” гэсэн зарчмыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

Авлага:

Хуулийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эзэн холбогдогч нь олдохгүй, нас барсан иргэдтэй холбоотой 91.9 сая төгрөгийн авлагыг данснаас хасаагүй, найдваргүй авлагын хасагдуулга тооцоогүй, дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 4.2.4-д төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь 4.1.1-д “*санхүүгийн тайлагналын олон улсын стандарт*”-ыг мөрдөнө гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулж найдваргүй авлагын хасагдуулга тооцож авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр нь бүртгэсэн.

Биет бус хөрөнгө:

Тайлант хугацаанд Монгол улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 193 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгасан. Энэ үнэлгээний тайлангаарх газар эзэмших эрхийн үнэлэгдсэн дүнг бүртгэлд тусгахдаа “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 116.2 сая төгрөгөөр дутуу, “Дөргөний усан цахилгаан станц” ХХК нь 86.3 сая төгрөгөөр илүү бүртгэж тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5.1.4-д “*үнэн зөв байх*” гэсэн зарчмыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

Урт хугацаат зээлийн хүүний өглөг, зардал:

“Дөргөний усан цахилгаан станц” ХХК нь Монгол улсын сангийн яамтай 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 190 тоот дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 3,375.3 сая төгрөгийн зээлийн хүүний өр төлбөрийг бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6.1-д “*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө*” гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад аудиторын зүгээс Монгол улсын сангийн яамны санхүү бодлогын газрын өрийн удирдлагын хэлтэст эерэг тулган баталгаажуулах захидал илгээж, хариуг авч зээлийн хүүний өр төлбөрийг залруулан бүртгэж тайлагнуулсан.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	30.0	Он дамжсан авлага бүртгэлтэй.
2	Албан шаардлага өгсөн	1	194.1	Гэрээ хийгээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй.
3	Зөвлөмж өгсөн	1	-	Дотоод хяналт хийх арга, аргачлал болох бодлого байхгүй.
4	Зөвлөмж өгсөн	1	-	НББ-ийн бодлогын баримт бичгийг шинэчлээгүй.
5	Зөвлөмж өгсөн	1	-	Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн бүртгэл хийдэггүй.
	Дүн	5	224.1	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Авлага:

“Увс цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь “Увс дулааны станц” ХХК-иас 194.1 сая төгрөгийн эрчим хүчний авлагын үлдэгдэлтэй байна. Авлагын үлдэгдлийг сүүлийн 2 жилийн хугацаанд тооцоо нийлж баталгаажуулаагүй, харилцагч байгууллагатай гэрээ байгуулж чадаагүй байна. Аудиторын зүгээс дээрх байгууллагуудад эерэг тулган баталгаажуулах захидал илгээсэн боловч хариу ирүүлээгүй тул үлдэгдлийг үнэн зөв эсэхийг баталгаажуулж чадаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлагаас “Увс дулааны станц” ХХК-тай эрчим хүчээр хангах гэрээ байгуулах, 2018 оны жилийн эцсийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах ажлыг холбогдох дээд шатны байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллан зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэх.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар томоохон харилцагч байгууллагуудтай холбоотой авлага, өр төлбөрийн барагдуулалт, татварын бүртгэл хөтлөлт болон татварын өр төлбөрийн талаар дахин хянан үзэх шаардлагатай.

Тайлант хугацаанд Монгол улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 193 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд газар эзэмших, ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийг үнэлж, Сангийн сайдын 2018 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 207 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу санхүүгийн тайланд дахин үнэлгээний үр дүнг бүртгэж тайлагнасан. Тус дахин үнэлгээгээр биет бус хөрөнгө (газар эзэмших эрх) 2,058.3 сая төгрөг, барилга, байгууламж 4,115.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Дахин үнэлгээний тайлан хараат бус хөндлөнгийн үнэлгээчин Д.Мягмарсүрэн хянан шалгасан байна.

2.10 Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 666 дугаар тогтоолоор 15,350.9 сая төгрөгийн орлого, 26,518.1 сая төгрөгийн зардалтай, 7,818.2 сая төгрөгийн улсын төсвийн татаас авч 3,349.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь тайлант онд 27,820.7 сая төгрөгийн нийт орлоготой, 32,915.1 сая төгрөгийн зардалтай, 2.1 сая төгрөгийн орлогын албан татвар төлж, 5,096.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Алдагдалд түгээх компаниуд болон ОХУ-д төлж байгаа цахилгааны төлбөр, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өссөн, мөн урт хугацаат зээлийн хүүний зардлыг балансад тусгасан зэргээс алдагдал нэмэгдсэн.

2.11 Шилэн дансны мэдээлэл

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 4 дүгээр бүлэгт заасны дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад, оруулах шаардлагатай мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгсөнөөс 100 хувь бүрэн биелүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Бодлого, журамтай холбоотой асуудал:

3.1.1. Илрүүлэлт:

- Компани 2016 онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч СТОУС болон гол үйл ажиллагааны онцлог шинжийг тусгаагүй байна. Тухайлбал: өөрөө үйлдвэрлэсэн, дотоодоос худалдан авсан, импортоор худалдан авсан эрчим хүчний өртгийг хэрхэн бүртгэх, тэдгээр эрчим хүчийг үйлдвэрлэх, түгээх, борлуулах, дамжуулахад үүссэн эрчим хүчний алдагдлыг хэвийн болон хэвийн бусаар нь ялгаж бүртгэх талаар бодлогын баримт бичигт нарийвчлан заагаагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-д *“Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”*, 20.2.2-д *“Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах”* гэж тус тус заасныг зөрчсөн байна.

- Компани дотоод аудитор, дотоод хяналтын ажилтантай боловч дотоод хяналт хийх арга аргачлал болох заавар, журамгүй байна.

Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1-д *“Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”*, төрийн өмчийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 67.1-д *“Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”* гэж тус тус заасныг зөрчсөн байна.

3.1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, борлуулсан бүтээгдэхүүний өртөг буруу тооцоологдох, татварын эрсдэл үүсэх, алдаа зөрчил тухайн цаг хугацаандаа засагдахгүй байх, алдаа зөрчил давтагдан гарах, улмаар санхүүгийн болон татварын эрсдэл үүсэх.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Компанийн үндсэн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах. Мөн дотоод хяналт хийх арга аргачлал болох заавар журмыг боловсруулан мөрдөж ажиллах. Уг заавар журмын дагуу компанийн санхүүгийн бүртгэл хөтлөлт, татварын бүртгэл хөтлөлт, хөрөнгийн ашиглалт хамгаалалт, худалдан авалт, зарцуулалт, холбогдох хуулийн шаардлага, заавар, журмыг биелүүлэн ажиллаж байгаа эсэхэд болон шууд харьяалагдах дээд байгууллагаас үүрэг болгосон аливаа зүйлүүдэд төлөвлөгөөт болон гэнтийн шалгалт хийж үр дүнг нь аудитын хороонд тайлагнаж байх.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийн дагуу нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт сайжируулалт хийнэ. Шугамын болон арилжааны алдагдлыг хэрхэн бүртгэж тайлагнах талаар холбогдох дээд байгууллагуудаас зөвлөгөө авч ажиллана. Мөн дотоод хяналт хийх журмыг боловсруулан ажиллана.

3.2. Авлага, өр төлбөрийн талаар:

3.2.1. Илрүүлэлт:

- “Увс цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь “Шинжиан шинфа” ХХК-иас 30.0 сая төгрөгийн он дамжсан авлагын үлдэгдэлтэй байна. Тус авлага нь гудамж төслийн хүрээнд агаарын шугамын шинэчлэлийн ажил хийгдсэн.

Энэ нь санхүүгийн тайлагналын их бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д *“өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдээгдлийг тооцсон байх”* гэж заасныг зөрчсөн байна.

- Компанийн хэмжээнд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн бүртгэл хөтлөж бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, их бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 4.2.4-д *“төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж”* нь 4.1.1-д *“санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”-ыг* мөрдөнө гэж заасныг зөрчсөн.

3.2.2. Эрсдэл:

Авлага, өр төлбөр барагдахгүйгээс насжилт ихэсэх, найдваргүй авлага үүсэх, дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй тохиолдолд алданги тооцогдох, холбогдох стандарт, журмыг зөрчих эрсдэл үүсэх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулж ажиллах. НББОУС-12 "Орлогын албан татвар", Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалын хавсралт *“Татварын өмнөх ашгаас татвар ногдуулах орлогыг тодорхойлох, үүсэх зөрүүг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлал”-д* тус тус заасны дагуу Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэх эсэх талаар холбогдох дээд шатны байгууллагаас зөвлөгөө авч ажиллах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,023,093,640.65	386,717,238.66
1.1.2	Дансны авлага	1,666,946,365.69	1,550,408,139.94
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	15,855,595.97	1,383,434.13
1.1.4	Бусад авлага	96,647,128.38	59,500,371.51
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	00.00	00.00
1.1.6	Бараа материал	1,015,203,026.65	1,073,114,115.41
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	616,810,907.60	148,192,083.50
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	00.00	00.00
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,434,556,664.94	3,219,315,383.15
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	74,604,348,732.52	78,219,553,802.36
1.2.2	Биет бус хөрөнгө	115,869,989.95	2,229,057,836.89
1.2.3	Биологийн хөрөнгө	00.00	00.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	00.00	00.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	00.00	00.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	00.00	00.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	00.00	00.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	00.00	00.00
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	74,720,218,722.47	80,448,611,639.25
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	79,154,775,387.41	83,667,927,022.40
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	686,607,805.73	2,978,303,871.98
2.1.1.2	Цалингийн өглөг	12,478,369.16	10,560,716.26
2.1.1.3	Татварын өр	1,108,870,803.05	1,379,791,124.23
2.1.1.4	НДШ-ийн өглөг	74,807,805.85	27,625,751.72
2.1.1.5	Богино хугацаат зээл	00.00	00.00
2.1.1.6	Хүүний өглөг	216,760,316.57	3,769,532,660.97
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	00.00	00.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	39,476,596.00	47,699,555.00

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн, санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.9	Нөөц (өр төлбөр)	00.00	00.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	62,887,920.78	85,243,245.46
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	00.00	00.00
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,201,889,617.14	8,298,756,925.62
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	35,737,455,975.82	35,737,455,975.82
2.1.2.2	Нөөц (өр төлбөр)	00.00	00.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	00.00	00.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	35,000,000.00	35,000,000.00
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	35,772,455,975.82	35,772,455,975.82
2.2	Өр төлбөрийн нийт дүн	37,974,345,592.96	44,071,212,901.44
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	52,779,560,590.07	53,761,631,549.95
2.3.2	- хувийн	00.00	00.00
2.3.3	- хувьцаат	00.00	00.00
2.3.4	Халаасны хувьцаа	00.00	00.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	00.00	00.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,658,485,129.60	5,763,630,095.45
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	00.00	00.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	476,793,182.05	2,058,278,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-13,734,409,107.27	-21,986,825,524.44
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	41,180,429,794.45	39,596,714,120.96
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	79,154,775,387.41	83,667,927,022.40

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	14,362,142,718.67	19,298,241,108.67
2	Борлуулалтын өртөг	22,228,994,594.41	27,417,052,282.85
3	Нийт ашиг (алдагдал)	-7,866,851,875.74	-8,118,811,174.18
4	Түрээсийн орлого	00.00	00.00
5	Хүүний орлого	84,336,155.74	21,255,293.12
6	Ногдол ашгийн орлого	00.00	00.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	00.00	00.00
8	Бусад орлого	7,978,579,352.41	8,497,987,465.40
9	Борлуулалт, маркетингийн зардал	-2,114,768,038.33	-2,478,642,508.23
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-1,836,605,888.57	-2,059,140,527.63
11	Санхүүгийн зардал	-36,565,235.23	-307,148,893.50
12	Бусад зардал	-267,751,692.49	-250,360,326.78
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-17,034,948.66	-163,753,716.78
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	00.00	3,200,000.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	00.00	00.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	00.00	00.00
17	Бусад ашиг (алдагдал)	-124,881,730.92	-239,023,148.74
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-4,201,543,901.79	-5,094,437,537.32
19	Орлогын татварын зардал	8,433,615.59	-2,125,529.30
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-4,209,977,517.38	-5,096,563,066.62
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	00.00	00.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-4,209,977,517.38	-5,096,563,066.62
23	Бусад дэлгэрэнгүй орлого	00.00	00.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	00.00	00.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00
	Бусад олз (гарз)	00.00	00.00
24	Орлогын нийт дүн	-4,209,977,517.38	-5,096,563,066.62
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	00.00	00.00

4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	52,779,560,590.07	1,658,485,129.60	00.00	-9,283,221,376.54	45,154,824,343.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	00.00	00.00	00.00	-241,210,213.35	-241,210,213.35
Залруулсан үлдэгдэл	52,779,560,590.07	1,658,485,129.60	00.00	-9,524,431,589.89	44,913,614,129.78
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	00.00	00.00	00.00	-4,209,977,517.38	-4,209,977,517.38
Бусад дэлгэрэнгүй орлого	00.00	00.00	00.00	00.00	00.00
Өмчид гарсан өөрчлөлт	00.00	00.00	476,793,182.05	00.00	476,793,182.05
Зарласан ногдол ашиг	00.00	00.00	00.00	00.00	00.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	52,779,560,590.07	1,658,485,129.60	476,793,182.05	-13,734,409,107.27	41,180,429,794.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	00.00	00.00	00.00	-3,155,853,350.51	-3,155,853,350.51
Залруулсан үлдэгдэл	52,779,560,590.07	1,658,485,129.60	476,793,182.05	-16,890,262,457.78	38,024,576,443.94
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	00.00	00.00	00.00	-5,096,563,066.66	-5,096,563,066.66
Бусад дэлгэрэнгүй орлого	00.00	00.00	00.00	00.00	00.00
Өмчид гарсан өөрчлөлт	982,070,959.88	00.00	1,581,484,817.90	00.00	2,563,555,777.83
Зарласан ногдол ашиг	00.00	00.00	00.00	00.00	00.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	00.00	4,105,144,965.85	00.00	00.00	4,105,144,965.85
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	53,761,631,549.95	5,763,630,095.45	2,058,277,999.95	-21,986,825,524.44	39,596,714,120.96

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	21,415,142,288.99	20,611,854,339.37
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	12,392,680,015.25	11,065,726,399.62
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	00.00	64,365,441.32
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	9,199,020.00	11,042,845.00
	Буцаан авсан албан татвар	00.00	00.00
	Татаас, санхүүжилтийн орлого	8,599,966,600.00	8,599,966,600.00
	Бусад мөнгөн орлого	413,296,653.74	870,753,053.43
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-22,992,292,721.88	-20,416,520,815.38
	Ажиллагчдад төлсөн	-4,000,857,784.57	-4,472,767,505.91
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-825,782,314.39	-1,126,959,634.49
	Бараа материал худалдан авахад төлсөн	-9,127,474,232.70	-8,778,612,475.85
	Ашиглалтын зардалд төлсөн	-4,753,518,716.26	-1,420,741,490.21
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-211,426,443.90	-305,298,392.77
	Хүүний төлбөрт төлсөн	-54,000.00	00.00
	Татварын байгууллагад төлсөн	-2,258,789,619.18	-2,496,436,888.74
	Даатгалын төлбөрт төлсөн	-26,703,012.00	-8,982,637.00
	Бусад мөнгөн зарлага	-1,787,686,598.88	-1,806,721,790.42
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,577,150,432.89	195,333,523.99
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	102,241,023.51	24,943,185.96
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	5,825,000.00	11,137,500.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	00.00	00.00
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	00.00	00.00
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	00.00	00.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	00.00	00.00
	Хүлээн авсан хүүний орлого	95,319,468.74	13,805,685.96
	Хүлээн авсан ноогдол ашиг	1,096,554.77	00.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-541,943,365.81	-856,751,390.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-479,899,775.60	-749,026,440.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-61,894,000.00	-54,620,550.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-149,590.21	-53,099,400.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	00.00	00.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	00.00	-5,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-439,702,342.30	-831,808,204.04
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	00.00	00.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	00.00	00.00

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн, санхүүгийн тайлангийн аудит

	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	00.00	00.00
	Төрөл бүрийн хандив	00.00	00.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	00.00	00.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	00.00	00.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	00.00	00.00
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	00.00	00.00
	Төлсөн ногдол ашиг	00.00	00.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	00.00	00.00
4.1	Валютын ханшийн зөрүү	2,899,679.62	98,278.06
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-2,013,953,095.57	-636,376,401.99
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,037,046,736.22	1,023,093,640.65
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,023,093,640.65	386,717,238.66

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн, санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019.03.15			САГ-2019/89/СТА-ТӨХК
Шалгагдсан байгууллагын нэр:	Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	"Увс цахилгаан түгээх сүлжээ" ХХК нь Шинжиан шинфа ХХК-наас 30.0 сая төгрөгийн он дамжсан авлагын үлдэгдэлтэй байна. Тус авлага нь гудамж төслийн хүрээнд агаарын шугамын шинэчлэлийн ажил хийгдсэнтэй холбоотой байна. Энэ нь санхүүгийн тайлагналын их бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдээгдлийг тооцсон байх" гэж заасныг зөрчсөн байна.	30.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Р.Нямтуул
2	Компанийн хэмжээнд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн бүртгэл хөтлөж бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, их бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 4.2.4-д "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж" нь 4.1.1-д "санхүүгийн тайлагналын олон улсын стандарт"-ыг мөрдөнө гэж заасныг зөрчсөн.	-	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Р.Нямтуул
3	Компани 2016 онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч СТОУС болон гол үйл ажиллагааны онцлог шинжийг	-	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Р.Нямтуул

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн, санхүүгийн тайлангийн аудит

	тусгаагүй байна. Энэ нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-д <i>“Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”</i> , 20.2.2-д <i>“Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах”</i> гэж заасныг зөрчсөн байна.				
4	"Увс цахилгаан түгээх сүлжээ" ХХК нь "Увс дулааны станц" ХХК-аас 194.1 сая төгрөгийн эрчим хүчний авлагын үлдэгдэлтэй байна. Авлагын үлдэгдлийг сүүлийн 2 жилийн хугацаанд тооцоо нийлж батлагаажуулаагүй, харилцагч байгууллагатай гэрээ байгуулж чадаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д <i>“өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх”</i> гэж заасныг зөрчсөн байна.	194.1	Албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирал	Р.Нямтуул
5	Компани дотоод аудитор, дотоод хяналтын ажилтантай боловч бодох дотоод хяналт хийх арга аргачлал болох заавар, журамгүй байна. Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1-д <i>“Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”</i> , төрийн өмчийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 67.1-д <i>“Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна ”</i> гэж заасныг зөрчсөн байна.	-	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Р.Нямтуул
Дүн		224.1			

